



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2022 оны 05 сарын 21 өдөр

Дугаар 99

Улаанбаатар хот

**“Үндэсний давхар даатгал” хувьцаат компани  
нэмэлт хувьцаа гарган, хөрөнгийн биржээр олон нийтэд  
нээлттэй арилжих тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 56 дугаар зүйлийн 2.1, 2.2 дахь хэсэг, Улсын Их Хурлын 2022 оны 16 дугаар тогтоол, Засгийн газрын 2022 оны 244 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Үндэсний давхар даатгал” хувьцаат компанийн 245,000,000 (хоёр зуун дөчин таван сая) ширхэг энгийн хувьцаа дээр 61,250,000 (жаран нэгэн сая хоёр зуун тавин мянга) ширхэг энгийн хувьцааг нэмж гаргаж, хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтэд нээлттэй санал болгосугай.

2. Олон нийтэд санал болгох нэгж хувьцааны үнийг 188 (нэг зуун наян найман) төгрөгөөр тогтоосугай.

3. “Үндэсний давхар даатгал” хувьцаат компанийн хувьцааг хөрөнгийн биржээр арилжих үйл ажиллагааг Үнэт цаасны тухай хуульд заасан журмын дагуу зохион байгуулахыг “Үндэсний давхар даатгал” хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (Ч.Тавинжил), Гүйцэтгэх захирал (Б.Жавхлант) нарт тус тус зөвшөөрсүгэй.

4. “Үндэсний давхар даатгал” хувьцаат компанийн хувьцааг хөрөнгийн биржээр арилжих үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус компанийн Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид зөвлөсүгэй.

5. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

132004618  
8-r huraldaan.docx